



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 64

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 50,000,000 /тавин сая/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй 63-01 ДУЭ улсын дугаартай Тоёота Ланд 200 маркын автомашиныг Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Н.Мөнгөнцоож, Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Оюунчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 03-р улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



430219157

58

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2019 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 10

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 09 сарын 02 ны өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлээс :

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай /Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн хуучин барилга/

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Дундговь аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, Орон нутгийн өмчийн дарга А.Ууганбаяр нар танилцуулав. Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2014 оны 13-07-017/107 дугаар дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон 19,254,575 /арван есөн сая хоёр зуун тавин дөрвөн мянга таван зуун далан тав/ төгрөгийн балансын үнэтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн Хүүхдийн цэцэрлэгийн барилга, 1,065,000 /нэг сая жаран таван мянга/ төгрөгийн балансын үнэтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн Хүүхдийн цэцэрлэгийн хашааг тус тус акталж данснаас хасах саналтай байна гэж танилцууллаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн олонхийн саналаар Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн хуучин барилга болон хашааг үнэ тогтоож дуудлага худалдаагаар оруулах нь зүйтэй гэж үзэж байна” гэжээ

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

